



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Дархан сумын 23 дугаар цэцэрлэг 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2026/82/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр: Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn</p> <p>Аудитор: Ч.Мөнхбаяр Утас: 89275858 Цахим хаяг: tsesb.audit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059.
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 109

танай _____-ны № _____-т

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
23 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Д.ЭРДЭНЭЧИМЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 23 дугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан Уул аймгийн Дархан сумын 23 дугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант хугацаанд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 8,120.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер, Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 20,646.0 мянган төгрөгийн гал тогооны тоног төхөөрөмж, цэцэрлэгийн эцэг, эхийн хандиваар хандивласан 9,170.0 мянган төгрөгийн тавилга, тоног төхөөрөмжүүдийг холбогдох дансанд бүртгэж, тайлагнасан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

4520050139

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлснээр цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал 792,431.8 мянган төгрөг болж өнгөрсөн оны гүйцэтгэлээс 19.8 хувиар өссөн байна.

Бусад асуудлын хэсэг

Дархан Уул аймгийн Дархан сумын 23 дугаар цэцэрлэгийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 44 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 98.6 хувиар тайлагнасан байна. Мөн улирал бүр аймгийн Боловсролын газарт ажлын тайланг хүргүүлж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	209,700,564.00	111,124,855.04
31	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	179,570,879.00	66,442,553.00
311	Кассанд байгаа	-	
312	Банкинд байгаа	179,570,879.00	66,442,553.00
3121	Төгрөг	179,570,879.00	66,442,553.00
31211	Төрийн сангийн харилцах	179,570,879.00	66,442,553.00
33	АВЛАГА	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	30,129,685.00	44,682,302.04
351	Түүхий эд материал	577,400.00	481,300.00
35130	Эм боох материал	577,400.00	481,300.00
354	Хангамжийн материал	29,552,285.00	44,201,002.04
35410	Бичиг хэргийн материал	2,738,000.00	5,669,861.04
35420	Аж ахуйн материал	21,050,903.00	33,305,523.00
3545	Барилгын засварын материал	2,375,000.00	2,375,000.00
35460	Хүнсний материал	3,388,382.00	2,850,618.00
35470	Бусад хангамжийн материал	-	-
36	НӨӨЦИЙН БАРАА		
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,277,197,056.14	1,284,669,922.63
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,277,197,056.14	1,284,669,922.63
392	Биет хөрөнгийн дүн	1,085,047,056.14	1,091,583,005.99
39201	Барилга байгууламж	1,120,749,769.00	1,120,749,769.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(106,120,128.24)	(125,311,369.32)
39205	Машин тоног төхөөрөмж	73,168,819.00	98,993,869.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(33,370,557.37)	(37,598,680.92)
39207	Тавилга, эд хогшил	30,630,050.00	36,684,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(13,304,841.71)	(9,966,408.51)
39214	Бусад үндсэн хөрөнгө	21,792,130.50	21,792,130.50
39215	Хуримтлагдсан элэгдэл	(11,794,546.08)	(13,760,303.76)
39217	Ном	3,296,361.04	-
393	Биет бус хөрөнгийн дүн	192,150,000.00	193,086,916.64
39301	Программ хангамж	1,124,300.00	1,124,300.00
39302	Хасагдуулга	(1,124,300.00)	(187,383.36)
39303	Бусад биет бус хөрөнгө	192,150,000.00	192,150,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,486,897,620.14	1,395,794,777.67
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,486,897,620.14	1,395,794,777.67
51	Засгийн газрын хувь оролцоо	597,694,037.00	597,694,037.00
511	Засгийн газрын оруулсан капитал	597,694,037.00	597,694,037.00
512	Хуримтлагдсан үр дүн	32,866,814.01	(58,236,028.46)
51210	Өмнөх үеийн үр дүн	32,866,814.01	32,866,814.01
51220	Тайлант үеийн үр дүн	-	(91,102,842.47)
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	856,336,769.13	856,336,769.13
6	ӨР ТӨЛБӨР БА ЭЗ/ӨМЧИЙН ДҮН	1,486,897,620.14	1,395,794,777.67

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	1,034,596,900.00	1,009,364,520.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	33,388,000.00	51,921,820.00
120	Нийтлэг татварын бус орлого	33,388,000.00	51,921,820.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,208,500.00	7,056,800.00
1200045	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,208,500.00	7,056,800.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	27,179,500.00	37,936,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	6,929,020.00
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,001,208,900.00	957,442,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	945,167,100.00	898,704,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	945,167,100.00	898,704,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүдгээс санхүүжих	-	
131103	ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	56,041,800.00	58,738,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	56,041,800.00	58,738,600.00
2	Үйл ажиллагааны зардал	954,932,748.78	1,100,467,362.47
21	Урсгал зардал	954,932,748.78	1,100,467,362.47
210	Бараа, үйлчилгээний зардал	950,614,516.03	1,093,275,055.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	661,182,994.00	792,431,810.00
210101	Үндсэн цалин	467,144,995.00	519,580,685.00
210102	Нэмэгдэл цалин	169,504,369.00	218,376,887.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		28,418,182.00
210104	Урамшуулал	24,533,630.00	26,056,056.00
210105	Гэрээтийн цалин	-	
2102	Нийгмийн даатгалын шимтгэл	86,301,696.00	96,271,266.00
210201	Тэтгэврийн даатгалын	58,910,981.00	65,482,966.00
210202	тэтгэмжийн даатгалын	7,338,921.00	7,699,500.00
210203	ҮОМШӨ-ий даатгалын	3,370,011.00	3,851,000.00
210204	Ажилгүйдлийн даатгалын	3,336,354.00	3,851,000.00
210205	ЭМ-ийн даатгалын	13,345,429.00	15,386,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,723,567.25	41,566,292.59
210301	Гэрэл цахилгааны зардал	6,577,303.49	8,134,386.00
210302	Түлш, халаалтын зардал	22,955,202.60	21,229,472.88
210303	Цэвэр бохир усны зардал	13,191,061.16	12,202,433.71
2104	Хангамж, бараа материалын зардал	3,831,880.00	-
210401	Бичиг хэргийн зардал	1,616,200.00	
210406	Бараа материал акталсны зардал	2,215,680.00	

2105	Нормативт зардал	95,213,420.00	92,606,914.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл		
210502	Хоол, хүнс	95,213,420.00	92,606,914.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,040,948.00	9,980,000.00
210604	Урсгал засварын зардал	8,040,948.00	9,980,000.00
2107	Томилолтын зардал	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс	1,381,200.00	2,891,800.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	1,381,200.00	2,891,800.00
2109	Бараа, үйлчилгээний бусад зардал	51,938,810.78	57,526,972.47
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,284,972.00	15,543,900.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	7,617,710.00	7,099,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	33,036,128.78	34,883,572.47
213	Урсгал шилжүүлэг	4,318,232.75	7,192,307.41
	Бусад урсгал шилжүүлэг		
	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал		
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,318,232.75	7,192,307.41
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,318,232.75	7,192,307.41
3	Үйл ажиллагааны үр дүн	79,664,151.22	(91,102,842.47)
145	Үйл ажиллагааны бус орлогын дүн		
225	Үйл ажиллагааны бус зардлын дүн		-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		
4	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
5	Үйл ажиллагааны нийт үр дүн	79,664,151.22	(91,102,842.47)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,001,208,900.00	957,442,700.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	-
120	Нийтлэг татварын бус орлого	-	-
120002	Хүүгийн орлого		
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,001,208,900.00	957,442,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	945,167,100.00	898,704,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	945,167,100.00	898,704,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	56,041,800.00	58,738,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	56,041,800.00	58,738,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	931,959,410.00	1,070,571,026.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	931,959,410.00	1,070,571,026.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	927,641,177.25	1,063,378,718.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	661,182,994.00	792,431,810.00
210101	Үндсэн цалин	467,144,995.00	519,580,685.00
210102	Нэмэгдэл	169,504,369.00	218,376,887.00
210103	Хоол унаа хөнгөлөлт		28,418,182.00
210104	Урамшуулал	24,533,630.00	26,056,056.00
2102	Ажил олгогчийн нийгмийн даатгалд төлөх шимтгэл	86,301,696.00	96,271,266.00
210201	Тэтгэврийн даатгалын	58,910,981.00	65,482,966.00
210202	Тэтгэмжийн даатгалын	7,338,921.00	7,699,500.00
210203	ҮОМШӨ-ий даатгалын	3,370,011.00	3,851,000.00
210204	Ажилгүйдлийн даатгалын	3,336,354.00	3,851,000.00
210205	Эрүүл мэндийн даатгалын	13,345,429.00	15,386,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,723,567.25	41,566,292.59
210301	Гэрэл цахилгааны зардал	6,577,303.49	8,134,386.00
210302	Түлш, халаалтын зардал	22,955,202.60	21,229,472.88
210303	Цэвэр бохир усны зардал	13,191,061.16	12,202,433.71
2104	Хангамж, бараа материал	-	-
210401	Бичиг хэргийн зардал		
2105	Нормативт зардал	96,683,320.00	92,069,150.00
210502	Хоол, хүнс	96,683,320.00	92,069,150.00
2106	Эд хогшил урсгал засвар	9,000,000.00	9,980,000.00

210604	Урсгал засвар	9,000,000.00	9,980,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын, үйлчилгээний төлбөр, хураамж	1,549,200.00	2,891,800.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	1,549,200.00	2,891,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,200,400.00	28,168,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,260,500.00	19,140,800.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	9,939,900.00	9,027,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,318,232.75	7,192,307.41
	Бусад урсгал шилжүүлэг		
	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал		
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,318,232.75	7,192,307.41
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,318,232.75	7,192,307.41
22	Хөрөнгийн зардал		
2220	Дотоод эх үүсвэрээр	-	-
225108	Бусад хөрөнгө		
3	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	69,249,490.00	(113,128,326.00)
4	Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн		
5	Хөрөнгө оруулалтын мөнгөн зарлагын дүн		-
22	Хөрөнгийн зардал	-	-
2200	Дотоод эх үүсвэрээр		-
223001	Бусад хөрөнгө		
6	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		-
7	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
8	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	69,249,490.00	(113,128,326.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		179,570,879.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		66,442,553.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны үр дүн
А	1	2	3	4
2023 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	597,694,037.00	856,336,769.13	(46,797,337.21)	1,407,233,468.92
НББ-ийн бодлогын өөрчлөлт				-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				-
ҮХ-ийн өсөлт, бууралт				-
ҮХ-ийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			79,664,151.22	79,664,151.22
2024 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	597,694,037.00	856,336,769.13	32,866,814.01	1,486,897,620.14
НББ-ийн бодлогын өөрчлөлт			-	-
ҮХ-ийн өсөлт, бууралт		-		-
ҮХ-ийн дахин үнэлгээний бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			(91,102,842.47)	(91,102,842.47)
2025 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	597,694,037.00	856,336,769.13	(58,236,028.46)	1,395,794,777.67

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-		
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,133,483,900.00	1,063,378,718.59	70,105,181.41	93.8
21	Урсгал зардлын дүн	1,133,483,900.00	1,063,378,718.59	70,105,181.41	93.8
210	Бараа үйлчилгээний зардал	1,133,483,900.00	1,063,378,718.59	70,105,181.41	93.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	822,876,000.00	792,431,810.00	30,444,190.00	96.3
210101	Үндсэн цалин	560,714,700.00	519,580,685.00	41,134,015.00	92.7
210102	Нэмэгдэл	240,280,500.00	218,376,887.00	21,903,613.00	90.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт		28,418,182.00	(28,418,182.00)	
210104	Урамшуулал	21,880,800.00	26,056,056.00	(4,175,256.00)	119.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	102,379,200.00	96,271,266.00	6,107,934.00	94.0
210201	Тэтгэврийн даатгал	64,033,600.00	65,482,966.00	(1,449,366.00)	102.3
210202	Тэтгэмжийн даатгал	8,228,800.00	7,699,500.00	529,300.00	93.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,114,300.00	3,851,000.00	263,300.00	93.6
210204	Ажилгүйдлийн даатгал	4,114,300.00	3,851,000.00	263,300.00	93.6
210205	ЭМД-ын хураамж	16,457,500.00	15,386,800.00	1,070,700.00	93.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,728,300.00	41,566,292.59	13,162,007.41	76.0
210301	Гэрэл цахилгааны зардал	12,732,500.00	8,134,386.00	4,598,114.00	63.9
210302	Түлш, халаалтын зардал	27,337,400.00	21,229,472.88	6,107,927.12	77.7
210303	Цэвэр бохир усны зардал	14,658,400.00	12,202,433.71	2,455,966.29	83.2
2104	Хангамж, бараа материалын зардал	-	-	-	
210401	Бичиг хэрэг		-	-	
2105	Нормативт зардал	108,648,900.00	92,069,150.00	16,579,750.00	84.7
210502	Хоол хүнс	108,648,900.00	92,069,150.00	16,579,750.00	84.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,980,000.00	9,980,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	9,980,000.00	9,980,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	4,886,200.00	2,891,800.00	1,994,400.00	59.2
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	4,886,200.00	2,891,800.00	1,994,400.00	59.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,985,300.00	28,168,400.00	1,816,900.00	93.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,957,700.00	19,140,800.00	1,816,900.00	91.3

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,027,600.00	9,027,600.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ			-	
26	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-	-	
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг			-	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-	-	
223001	Бусад хөрөнгө			-	
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,133,483,900.00	950,250,392.59	183,233,507.41	83.8
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	906,797,300.00	898,704,100.00	8,093,200.00	99.1
131001	Улсын төсвөөс санхүүжих	906,797,300.00	898,704,100.00	8,093,200.00	99.1
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	64,708,300.00	51,546,292.59	13,162,007.41	79.7
132001	Орон нутгийн төсвөөс	64,708,300.00	51,546,292.59	13,162,007.41	79.7
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	161,978,300.00	-	161,978,300.00	0.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		-	-	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих			-	
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	161,978,300.00		161,978,300.00	0.0
			-	-	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		179,570,879.00		
	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл		66,442,553.00	66,442,553.00	
001	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ			-	
002	БАЙГУУЛЛАГЫН ТОО			-	
003	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0
	АЖИЛЛАГСАДЫН ТОО	34.00	33.00	(1.00)	97.1
	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
	Гүйцэтгэх ажилтан	22.00	21.00	(1.00)	95.5
	Үйлчлэх ажилтан	11.00	11.00	-	100.0

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 21,392.7 мянган төгрөгийн алдаа илэрч аудитын явцад залруулав. Үүнд:

- Тус цэцэрлэгийн хөрөнгөнд тооллого хийхэд БГ-ын хөрөнгө оруулалтаар 17 нэр төрлийн хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, сав суулга, багаж хэрэгсэл нийлүүлсэнийг эрх бүхий байгууллагаас шийдвэр ирээгүй нь улмаас үндсэн хөрөнгийн дансанд бүртгээгүй байна.

Аудитаар нийт 2,744.0 мянган төгрөгийн зөрчил¹ илэрсэн тул төсвийг хохиролгүй болгох 600.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 2,144.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүллээ.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Илрүүлэлт: Тайлант онд тус сургуулийн хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардлаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан захирал Д.Эрдэнэчимэг сургалтын төлбөрт 600.0 мянган төгрөг төлж, батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 39 дүгээр тогтоолоор баталсан “Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам”-ын хавсралт “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээний бүрэлдэхүүн, зардлын зориулалт, эдийн засгийн ангиллын дэлгэрэнгүй заавар”-ын 7-д “Багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих зардал (Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх) буюу Багшийн хөгжил буюу мэргэжил дээшлүүлэх зардалд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны хөгжих хэрэгцээнд суурилсан цахим платформд түшиглэн явуулах тусгай сургалт (1, 5, 10 жилийн сургалтаас бусад), бусад сургалт үйл ажиллагааны зардал багтана.” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

5.2 Албан шаардлага

5.1.1 Илрүүлэлт: Тайлант онд тус сургуулийн захирал Д.Эрдэнэчимэг нь Дархан-Уул аймгийн Боловсролын газрын даргын 2025 оны А/94 дүгээр тушаалыг үндэслэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл цалин хөлсөнд нийт 2,144.0 мянган төгрөг авч, хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д “Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д “Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын захирал /эзэн/, ажил олгогч шууд хариуцна”, 27.6-д “Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтцийн жишиг, ажилтны орон тооны норматив, зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална”, Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 дүгээр тушаалын 1.В дэх хэсэгт “Төрийн болон төрийн үйлчилгээний төсвийн байгууллага ажилтны тооноос хамаарахгүйгээр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг аль нэг ажилтанд хавсран хариуцуулна. Хавсран ажиллуулсан тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

зүйлд заасны дагуу үндсэн ажлын цалингийн 40 хүртэлх хувийн нэмэгдэл хөлс олгоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

5.1 Зөвлөмж

Санхүүгийн тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмж байхгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тус цэцэрлэгийн хөрөнгөнд тооллого хийхэд БГ-ын хөрөнгө оруулалтаар 17 нэр төрлийн хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, сав суулга, багаж хэрэгсэл нийлүүлсэнийг эрх бүхий байгууллагаас шийдвэр ирээгүй нь улмаас үндсэн хөрөнгийн дансанд бүртгээгүй байна.	1	21,392.7	1	21,392.7	-	-	-	21,392.7	-	-	-	-
Дүн	1	21,392.7	1	21,392.7	-	-	-	21,392.7	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		/мянган төгрөгөөр/		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант онд тус сургуулийн хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардлаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан захирал Д.Эрдэнэчимэг сургалтын төлбөрт 600.0 мянган төгрөг төлж, батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.	1	600.0	1	600.0					-	-	-	-

Тайлант онд тус сургуулийн захирал Д.Эрдэнэчимэг нь Дархан-Уул аймгийн Боловсролын газрын даргын 2025 оны А/94 дүгээр тушаалыг үндэслэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл цалин хөлсөнд нийт 2,144.0 мянган төгрөг авч, хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.	1	2,144.0			1	2,144.0						
Дүн	1	2,744.0	1	600.0	1	2,144.0	-	-	-	-	-	-